



Аламеда мужийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний агентлаг
Нийгмийн эрүүл мэндийн газар

www.acphd.org Николас Мосс, АУД Эрүүл мэндийн газрын захирал

Нийгмийн эрүүл мэндийн газар: Үндсэн дугаар (510) 267-8000

КОВИД-19 халдварын мэдээлэл: (510) 268-2101

Коллин Чавла, захирал
Кими Уоткинс-Тарт, Захирал

ХЭНД: Аламеда мужийн бүх ажил олгогчид

ХЭНЭЭС: Николас Ж.Мосс, АУД, НЭММ, Эрүүл мэндийн газар

СЭДЭВ: Тохиолдол, ойрын хавьталтай холбоотойгоор ажилдаа буцаж орох удирдамж

Аламеда дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн газар (АКНЭМГ) Аламеда каунтид ажилладаг эсвэл амьдардаг хүн бүрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг. Амны хаалт зүүхийг шаардах, хүн бүрийг бие биеэсээ 6 фийт зай бариулах, шинж тэмдгийн тогтмол үзлэг хийх, өвчтэй ажилчдыг гэртээ байхад нь дэмжлэг үзүүлэх зэргээр ажлын байрны аюулгүй байдалтай холбоотой мужийн болон орон нутгийн шаардлагыг хангаж ажиллаж байгаад тань бид талархаж байна.

КОВИД-19 халдвар манай орон нутагт өргөн тархсан бөгөөд вирусийн халдвар авсан ажилтнууд танайд байж болно. Манай Эрүүл мэндийн газрын захирлын тушаалын дагуу КОВИД-19 өвчний халдвартай хүмүүс вакцин хийлгэсэн эсэх үл хамааран хэсэг хугацаанд гэртээ байж, бусдаас тусгаарлах шаардлагатай.

Үүний нэгэн адил тодорхой шалгуурыг хангаагүй бол манай Эрүүл мэндийн газрын захирлын тушаалын дагуу КОВИД-19 өвчин туссан олон хүнээс гэртээ байж, бусдаас тусгаарлахыг шаардаж байна.

Ажил олгогч нар тусгаарлалт, хорио цээрийн дэглэмийн өнөөгийн шаардлагын талаар мэдээлэл авахын тулд дараах холбоосыг ашиглах хэрэгтэй. Ажилчид ажилдаа буцаж орох боломжтой эсэхийг тодорхойлохын тулд КОВИД-19 өвчний шинжилгээг ашиглах эсэх, яаж ашиглахаа шийдэхдээ доорх веб хуудсанд буй зааврыг дагаж мөрдөхийг ажил олгогчид зөвлөж байна.

- Олон нийтэд зориулсан тусгаарлалт, хорио цээрийн хүчин төгөлдөр үйлчилж буй зааврыг дараах веб хуудаснаас авч болно: <https://covid-19.acgov.org/isolation-quarantine>
 - **Тайлбар:** Тухайн салбарт (жишээ нь сургууль, эмнэлгийн байгууллага, засан хүмүүжүүлэх газар) зөвхөн хамааралтай заавар, тусгай шаардлагыг зарим ажлын байранд тавьж байгаа бөгөөд ажил олгогч аж ахуйн нэгж доор дурдсан Эрүүл мэндийн газрын захирлын тушаалаас нэмэлт мэдээлэл авах хэрэгтэй.
- Та Манай Эрүүл мэндийн газрын захирлын тусгаарлах, хорио цээрийн дэглэм сахих тухай тушаалыг эндээс үзэж болно. <https://bit.ly/AC-HOO>
- Ажлын байр Кал/ХААЭМА-ийн шаардлагыг дагаж мөрдөх ёстой бөгөөд эдгээрийг эндээс авч болно.
<https://www.dir.ca.gov/dosh/coronavirus/>

АКНЭМГ хүмүүст ажилдаа буцаж ороход нь тодорхойлолт олгохгүй бөгөөд эмч эсвэл эмнэлгээс тодорхойлолт авахыг мөн зөвлөдөггүй. Хэрэв КОВИД-19 өвчний халдвар авсан нь тодорхой иргэн 5 хоногийн дараа тусгаарлахаа зогсоож болох эсэхийг тодорхойлохын тулд КОВИД-19 өвчний шинжилгээг ашиглаж байгаа бол эсрэгтөрөгчийн шинжилгээг ашиглах хэрэгтэй. Халдвар авснаас хойш PCR/NAAT шинжилгээний хариу хэдэн долоо хоногоос олон сар хүртэл эерэг гарч болох боловч тухайн хүн халдвар



Аламеда мужийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний агентлаг
Нийгмийн эрүүл мэндийн газар

www.acphd.org Николас Мосс, АУД Эрүүл мэндийн газрын захирал

Коллин Чавла, захирал
Кими Уоткинс-Тарт, Захирал

Нийгмийн эрүүл мэндийн газар: Үндсэн дугаар (510) 267-8000

КОВИД-19 халдварын мэдээлэл: (510) 268-2101

авсан эсвэл халдвартай гэдгийг илтгэхгүй. Тухайн хүн 11 дэх өдрөөс өмнө тусгаарлахаа зогсоох тохиолдолд зөвхөн сөрөг эсрэгтөрөгчийн шинжилгээ хийлгэх нь зүйтэй. Хэрэв хэн нэгний КОВИД-19 өвчний шинжилгээний хариу эерэг гарч, 10 хоног тусгаарлаж, шинж тэмдгийн шалгуурыг хангавал (шинж тэмдэг илрээгүй/шинж тэмдэг арилж буй, халуураагүй) бид дахин шинжилгээ хийлгэхийг зөвлөхгүй бөгөөд ажилдаа эргэн орохын тулд шинжилгээ өгөх ШААРДЛАГАГҮЙ.

Хамтран ажиллаж, манай иргэдийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж буйд тань баярлалаа.